9

ГОВЬСҮМБЭР АЙМАГ

**ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2023 оны 08 сарын 01 өдөр Дугаар А/110 Шивээговь сум

Өвөлжилт, хаваржилтын бэлтгэл
хангуулах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2, 59.1.23, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 279 дүгээр тогтоол “Хөдөө аж ахуйн салбарын 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах зарим арга хэмжээний тухай”, Монгол Улсын Ерөнхий сайдын 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн “2023-2024 оны өвөлжилт, хаваржилт болон ургац хураалтын бэлтгэл хангах тухай” 03 дугаар албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Сумын 2023-2024 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангуулах, хяналт тавих ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга: Д.Отгонжаргал
(Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд: С.Отгонбаатар
(1 дүгээр багийн Засаг дарга)
Ш.Чинболд
(Илчлэг-Шивээ орон нутгийн аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын захирал)
П.Ганчимэг
(Эрүүл мэндийн төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)
С.Энхцэцэг
(3 дугаар сургуулийн захирлын

42123 348

үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Б.Даваадолгор
(3 дугаар цэцэрлэгийн эрхлэгч)
Л.Түмэнцэцэг
(Соёлын төвийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Б.Шинэбаяр
(Цагдаагийн хэсгийн дарга, дэд хурандаа)
Ж.Чинбат
(Шивээ Сервис ХХК-ийн захирал)

Нарийн бичгийн дарга: П.Ганжаргал
(Мал аж ахуйн үйлдвэрлэлийн төлөвлөлт, менежмент, малын үржил, бүртгэлийн асуудал хариуцсан мэргэжилтэн)

2.Өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

3.Өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг чанартай зохион байгуулж, аж ахуйн нэгж, албан байгууллага, баг, хөдөөгийн малчин өрх тус бүрээр өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангуулан биелэлтэнд нь хяналт тавьж, ажлын тайлан, хэрэгжилтийн явцыг хугацаанд нь тайлагнахыг ажлын хэсгийн дарга (Д.Отгонжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ Ч.СУГАРМАА

Сумын Засаг даргын 2023 оны 08 дугаар
сарын 01 -ний өдрийн А/110 дугаар
захирамжийн хавсралт

## 2023-2024 ОНЫ ӨВӨЛЖИЛТ, ХАВАРЖИЛТЫН БЭЛТГЭЛ АЖЛЫГ ХАНГАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

2023. 08.01

| Удирдлага зохион байгуулалт | | | |
|---|---|---|---|
| № | Хийгдэх ажил | Хугацаа | Хариуцах эзэн |
| 1 | Сумын АБ, ААН–ээс өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөөг авч, сумын нэгдсэн төлөвлөгөө хийх | 7 сард | |
| 2 | 2023–2024 оны өвөлжилтийн бэлтгэл хангуулах ажлын комисс томилсон захирамж гаргуулах | 7 сард | |
| 3 | Комиссын хурал хийж, гишүүдэд ажлыг хуваарийн дагуу хариуцуулах | 7сард | |
| 4 | АБ, ААН–ийн өвөлжилтийн бэлтгэлийг хангах ажлын явцыг шалгах, үнэлэлт өгөх | 9 сард | |
| 5 | Байгууллагуудын өвөлжилтийн бэлтгэл ажил хангасан байдлыг шалган хүлээж авах | 10сард | |
| Эрүүл мэндийн төв | | | |
| 6 | Бүх өрөөний цонхны дулаалгыг хийх резин солих шороо орж ирэхээс сэргийлж торлох | 9 сарын 15 | Ахлах сувилагч, дарга, нягтлан, нярав |
| 7 | Шинэ эмнэлэг болон моорог, гадна эд агуулах скаладны дээврийн засвар үйлчилгээг хийх | 10 сарын 01 | Жолооч, үйлчлэгч, нярав |
| 8 | Эмнэлгийн гадна төмөр хаалга хашлага засварлах | 7 сарын 01 | Бүх ажилчид |
| 9 | Автомашины гражийн хаалганы засвар | 9 сарын 01 | Жолооч |

11

| | | | |
|---|---|---|---|
| | дулаалга хийх | | |
| 10 | Шинэ эмнэлгийн халаалтын шугам засварлах паар солих | 10 сарын 01 | Дарга, нягтлан, нярав |
| 11 | ЯТ-автомашины засвар үйлчилгээг, техникийн бүрэн бүтэн байдлыг хангах | 9 сарын 15 | Дарга, жолооч |
| 12 | Эрүүл мэндийн төвийн 2 давхарын барилгын дээврийг сольж ус бороо орохоос хамгаалах | 10 сарын 01 | Дарга, нягтлан, нярав, бусад ажилчид |
| 13 | Эмнэлгийн дотоод засал үйлчилгээ хийж хана шал цонхыг будаж сольж янзлах | 9-12сарын 01 | Дарга, нягтлан, нярав |
| 14 | Эрүүл мэндийн төвийн халаалтыг зохицуулж усны хоолой бохирын хоолойг засварлуулах | 10 сарын 01 | Дарга, нягтлан, нярав |
| | **Соёлын төв** | | |
| 15 | Байгууллагынхаа цонхыг дулаалах | 9 сард | Бүх ажилчид |
| 16 | Халаалтын шугам, өрөөнүүдийн парыг халаалт авахад бэлэн болгох | 9 сард | Бүх ажилчид |
| 17 | Байгууллагын дээвэр засварлах / соёлын төв, ЗДТГ/ | 9 сард | Бүх ажилчид |
| 18 | Байгууллагын бүх өрөө тасалгааны цахилгааны монтаж утаснуудыг шалгуулж засварлах | 8 сард | Бүх ажилчид |
| 19 | Байгууллагын арын хаалганы дулаалга хийх | 9 сард | Бүх ажилчид |
| | **3-р сургууль** | | |
| 20 | Сургуулийн хагарсан цонхыг шиллэх, дулаалах 8 сарын 05- 8 сарын 10 | 8 сарын 05- 8 сарын 10 | Төмөрчулуун, Энхтүвшин |
| 21 | Сургуулийн гаднах ханын засвар нөхөж, шавардаж шохойдох | 8 сарын 25- 8 сарын 30 | Бүх ажилчид |
| 22 | Ангиудын цонхоор дулаан алдалтыг хянаж дулаалга хийлгэх Сургуулийн | 9 сарын 13- 9 сарын 17 | Анги кабинет удирдсан багш нар, ажилчид |

| | | | |
|---|---|---|---|
| | гаднах ханын засвар нөхөж, шавардаж шохойдох | | |
| 23 | Сантехникийн шугамыг шалгаж зарим хэсэгт засвар хийх | 8 сарын 10 наас 8 сарын 25-ны дотор | Батсайхан, Энхтүвшин, Төмөрчулуун, Баянбилэг |
| 24 | Аваарын болон орох, гарах хаалгуудыг дулаалах | 9 сарын 1-ээс<br>9 сарын 5 | Батсайхан, Энхтүвшин, Төмөрчулуун, Баянбилэг |
| 25 | Дотуур байрны 00-ыг дулаалах | 9 сарын 10-аас 9 сарын 25 хооронд | . Батсайхан, Наранцацралт |
| 26 | Анги танхимын паарыг угаах | 8-р сарын 15 наас 8-р сарын 25 ны хооронд | Батсайхан, Энхтүвшин, Төмөрчулуун, Баянбилэг |
| 27 | Бохирын худгыг лайдах | 9-р сарын 15 | Батсайхан, Энхтүвшин, Төмөрчулуун |
| 28 | Сургуулийн гаднах элсийг цэвэрлэх | 8-р сарын 15-20 | Бүх ажилчид |
| **Илчлэг- шивээ онөүг** | | | |
| 29 | Нийтийн эзэмшлийн орон сууцнуудын шугам сүлжээг хэсэгчлэн солих, 250 метр зуухны барилгын болон үнсний хашааг шинэчлэх /20метр, блок/ | 3-р улирал | Зуухны мастер засварчид |
| 30 | 1 дүгээр өргөх станцын хашааг шинэчлэх, 10 боодол | 3-р улирал | . Зуухны мастер засварчид |
| 31 | 2 дугаар өргөх станцын хашааг шинэчлэх, 10 боодол | 2-р улирал | Зуухны мастер засварчид |
| 32 | Хөдөлгүүр хаалтууд худалдан авах | 2-р улирал | Нярав нягтлан |
| 33 | Халаалтын зуухнуудад урсгал засвар хийх | 2,3-р улирал | Бүх ажилчид |
| 34 | Шивээговь сумын хэрэглэгчдийг цэвэр усаар найдвартай хангах зорилгоор усны эх үүсвэрийн 2 дугаар худгийн цооногийг дурандах | 2-р улирал | Зуухны мастер засварчид |
| 35 | Бохирын бүх худгуудын лагыг цэвэрлэх | 2,3-р улирал | Зуухны мастер засварчид |

| | | | |
|---|---|---|---|
| 36 | Үнс зөөх | 2,3-р улирал | Зуухны мастер засварчид |
| 37 | Нүүрс худалдан авах | 3-р улирал | Зуухны мастер засварчид |
| 38 | Нүүрс тээврийн автомашин худалдан авах | 3-р улирал | Дарга нярав, нягтлан |
| | **3-р цэцэрлэг** | | |
| 39 | Байгууллагын өвөлжилтийн бэлтгэл ажлын төлөвлөгөө гаргах | 6-р сард | Эрхлэгч |
| 40 | Шаардлагатай хөрөнгийн хэмжээг тодорхойлон эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх | 7-8-р сард | Эрхлэгч |
| 41 | Цэцэрлэгийн гадна дотор орчинд урсгал засварын ажил хийж гүйцэтгэх | 7-8-р сард | Багш, ажилчид, нярав |
| 42 | Сантехникийн засварын ажил хийх | 8-р сард | Билэгдэмбэрэл, Нэргүй |
| 43 | Гэр цэцэрлэгийн туурга дээврийг оёж сэлбэх, засварлах. | 3 -р улиралд | Багш, ажилчид, нярав |
| 44 | Гэрийн буйр засах, гэр барих, хаяа манах, үүдний амбаар дулаалах, цэвэр ус холбох, бохир усны шугамд цэвэрлэгээ хийх, цахилгааны аюулгүй байдлыг хангах | 8 сард | Нярав, манаач нар, багш ажилчид |
| 45 | Гэр цэцэрлэгийн нүүрс аргал бэлтгэх | 9 сард | нярав |
| 46 | Хүнсний нарийн ногоо хөлдөөж хадгалах | 3 -р улиралд | Тогооч нар нярав |
| 47 | Аарц, ааруул ээзгий, байгалийн жимс нөөцлөх | 3-р улиралд | нярав |
| 48 | Цэцэрлэгийн хэмжээнд байгаа бүх цонх дулаалга хийх | 10-р сард | Туслах багш нар ажилчид |
| 49 | Гал тогооны 2 цонх солих | 10-р сард | Эрхлэгч |

| | | | |
|---|---|---|---|
| 50 | Гал тогооны дээвэр дулаалах, төмөрлөх. | 8 сард | Нярав, ажилчид |
| 51 | Хүнсний агуулахын дулаалга засвар үйлчилгээ хийх | 8 сар | Нярав, ажилчид |
| **ЗДТГ** | | | |
| 52 | Жижүүрийн өрөөний цонхыг солих | 7 сард | Жижүүрүүд |
| 53 | Сангийн засварын ажлыг хийлгэх | 8 сард | Нямдорж |
| 54 | ЗДТГ-ын дээврийг засварлаж ус борооноос хамгаалах | 8 сард | Ажлын хэсэг, бүх ажилчид |
| **ШИВЭЭ СЕРВИС** | | | |
| 55 | Уурхайчдыг эрүүл хүнсээр хангах зорилгын дагуу эрүүл мах, ногоог бэлтгэж, нөөцлөх чиглэлээр судалгаа хийж ажиллах | III улирал | Бүх ажилчид |
| 56 | Хөгжлийн төвийн дээврийн засварын ажил хийх | III улирал | Бүх ажилчид |
| 57 | ТДХ-ийн цайны газрын радиаторт засвар хийх, солих | III улирал | Бүх ажилчид |
| 58 | Уулын цайны газарт цонхны дулаалга хийж радиатар угаах | III улирал | Бүх ажилчид |
| 59 | Уулын цайны газрын бохирын худаг лайдаж шугамын их засварын ажил хийх | III улирал | Бүх ажилчид |
| 60 | Хөгжлийн төвийн бохирын худаг лайдах | III улирал | Бүх ажилчид |
| 61 | Бизнес хөгжлийн төвийн тэжээлийн шугамыг шинэчлэж солих | III улирал | Бүх ажилчид |
| 62 | КВм-1.25 3-р зуухыг шинээр суурилуулж, холболт монтажийн ажлыг гүйцэтгэж, туршилтын акт, баримт бичиг бүрдүүлэх | III улирал | Бүх ажилчид |
| 63 | Цахилгаан тоног төхөөрөмжийн | III улирал | Бүх ажилчид |

15

| | | | |
|---|---|---|---|
| | удирдлагын щитнүүдийн автомат пускателийг солих цэвэрлэгээ үйлчилгээ хийх | | |
| 64 | 12,13-р байрны гадна халаалтын шугамыг шинээр солих | III улирал | Бүх ажилчид |
| 65 | Гадна шугам сүлжээ, дулааны худгуудын халаалт арматурын засвар үйлчилгээ | III улирал | Бүх ажилчид |
| 66 | Зуухны тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээ /Үлээлгийн вентилятор, сүлжээ хэрэглээ, тэжээлийн насоснууд, дымосос, редукторуудын засвар/ | III улирал | Бүх ажилчид |
| 67 | Зуухны дотор шугам сүлжээний засвар үйлчилгээ хийх | III улирал | Бүх ажилчид |
| 68 | Утаа сорогчийн хоолой, циклоны хоолойг 3 мм лист төмөрөөр шинээр хийх | III улирал | Бүх ажилчид |
| 69 | Утаа сорогч димососыг шинээр суурилуулах | III улирал | Бүх ажилчид |

**ГҮЙЦЭТГЭЛИЙН ХУВЬ**

| Д/д | Арга хэмжээний тоо | Үүнэс | | | | Хийг дээгүй | Тасарсан | | Биелэлтийн дүн /хувиар/ |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Биел сэн /100/ | Хэрэгжих шатандаа | | | | Зохион байгуулалтаас | Хөрөнгийн эх үүсвэр дутагдсанаас | |
| | | | 70 | 30 | Хугацаа болоогүй | | | | |
| Бүгд | | | | | | | | | |

Төлөвлөгөө гаргасан

МАА-Н ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ, МЕНЕЖМЕНТ

МАЛЫН ҮРЖИЛ БҮРТГЭЛИЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН П.ГАНЖАРГАЛ